

GENCO TOUR BUREAU JSC

# ЖЕНКО ТУР БЮРО ХК 2021 ОНЫ ТАЙЛАН

| | |
|---|---|
| Компанийн оноосон нэр: | Женкотур бюро ХК |
| Үйл ажиллагааны чиглэл: | Аялал жуулчлал, Гадаад худалдаа, Хүнс ахуйн хэрэглээний барааны худалдаа, Бэлэг дурсгалын худалдаа |
| Бүтээгдэхүүн үйлчилгээ: | • Аялал<br>  • Дотоод аялал (Inbound)<br>  • Гадаад аялал (Outbound)<br>  • Бүх төрлийн тээврийн билет захиалга<br>  • Зочид буудлын өрөө захиалга<br>  • Гэр жуулчны бааз захиалга<br>  • Уламжлалт баяр наадам зохион байгуулах<br>  • Хурал, семинар зохион байгуулах<br>• Чингис хааны морьт хөшөө цогцолбор<br>  • Үзвэр үйлчилгээ<br>  • Түрээсийн үйлчилгээ<br>  • Кофе шоп<br>  • РесЙторан<br>• 13-р зуун цогцолбор<br>  • Үзвэр үйлчилгээ<br>  • Гэр жуулчны бааз<br>  • Ресторан<br>• Бэлэг дурсгалын худалдаа |
| Эрхэм зорилго: | Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох. |
| Бидний уриа: | Тухлах газрыг Та сонго Туулах замыг бид хөтөлье |
| Үүсгэн байгуулагдсан огноо: | 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан. |
| Компанийн удирдлага: | ТУЗ-ын дарга **Ү.ТЭМҮҮЖИН**<br>Гүйцэтгэх захирал Б.НАМУУН |
| Компанийн албан ёсны хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4, ЗИП код: 14251<br><br>Утас: 7012 0202<br>И-мэйл: info@genco-tour.mn<br>Веб хуудас: www.genco-tour.mn<br>Фэйсбүүк: Genco Tour Bureau |


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
ТУЗ
ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
АУДИТЫН ХОРОО
ЦАЛИН УРАМШУУЛАЛЫН ХОРОО
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
САНХҮҮГИЙН АЛБА
ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА
МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТЫН АЛБА
АЯЛЛЫН АЛБА
ЧИНГИС ХААНЫ МОРЬТ ХӨШӨӨ ЦОГЦОЛБОР
13-Р ЗУУН ЦОГЦОЛБОР

GENCO TOUR BUREAU JSC

2021 оны борлуулалтын орлого







2021 оны нийт борлуулалт 582сая төгрөг байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь КОВИД-19-н нөлөө одоог хүртэл хэвээр байгаа тул өнгөрсөн оныхтой төстэй гарсан байна.



GENCO TOUR BUREAU JSC

# 2021 ОН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ЗАДАРГАА

| Төрөл | Дүн | Хувь |
|---|---|---|
| | | |
| ЧХМХЦ | 452,213,991.03 | 77.62% |
| 13-р зуун | 89,554,440.93 | 15.37% |
| Бид хамтдаа | 8,635,454.56 | 1.48% |
| Эвэнт арга хэмжээ | 32,165,090.91 | 5.52% |

**Нийт дүн: 582,568,977.43**




- Нийт борлуулалтын орлогын дийлэнх буюу 73.88%-ийг ЧХМХ цогцолбор бүрдүүлж байгаа бөгөөд 4.92%-ийг гадаад аялал/бусад борлуулалт 15.67%-ийг 13-р зуун цогцолбор болон 5.53%-ийг Бид хамтдаа борлуулалт тус тус эзэлсэн байна.



| Зардлын нэр | 2020 оны зардал | 2021 оны зардал | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| ББӨ-ЧХМХЦ | 833,286,331 | 1,029,490,337 | **67.91%** |
| ББӨ-13 зуун | 321,404,718 | 190,912,689 | **12.59%** |
| Цалин | 192,141,832 | 116,530,150 | **7.69%** |
| Түрээс | 8,577,500 | 4,954,955 | **0.33%** |
| Зар сурталчилгаа | 6,188,652 | 13,082,758 | **0.86%** |
| Мэргэжлийн үйлчилгээ | 56,667,247 | 19,047,550 | **1.26%** |
| Найдваргүй авлага зардал | - | 50,463,572 | **3.33%** |
| Бусад зардлуудын дүн | 316,357,670 | 91,588,757 | **6.04%** |
| | **1,734,623,951** | **1,516,070,768** | |



# 2021 оны Зардлын задаргаа

| 2021 оны Зардал | Q1 | Q2 | Q3 | Q4 | НИЙТ |
|---|---|---|---|---|---|
| ББӨ - ЧХМХЦ | 155,896,803 | 334,254,571 | 212,307,259 | 327,031,704 | 1,029,490,337 |
| ББӨ - 13-р зуун | 12,024,077 | 50,074,323 | 71,124,496 | 57,689,793 | 190,912,689 |
| Цалин | 21,231,419 | 27,339,999 | 48,888,630 | 19,070,102 | 116,530,150 |
| Түрээс | 2,720,000 | 2,160,000 | | 74,955 | 4,954,955 |
| Зар сурталчилгаа | 726,335 | 1,078,402 | 4,353,253 | 6,924,768 | 13,082,758 |
| Мэргэжлийн үйлчилгээ | 6,455,014 | 185,000 | 12,243,445 | 164,091 | 19,047,550 |
| Найдваргүй авлагын зардал | 50,463,572 | | | 0 | 50,463,572 |
| Бусад | 18,417,872 | 27,989,301 | 8,582,665 | 36,598,737 | 91,588,575 |
| | **267,935,093** | **443,081,597** | **357,499,748** | **176,795,098** | **1,516,070,768** |

-Нийт ажилтан 48
-Дундаж цалин-829,469
-Мэргэжлийн үйлчилгээ /Аудитын төлбөр/



# 2021 оны зардлын задаргаа

| № | Зардлын нэр | Дүн | Хувь |
|---|---|---|---|
| 1 | ББӨ-ЧХМХЦ | 1,029,490,337 | 67.91% |
| 2 | ББӨ-13 зуун | 190,912,689 | 12.59% |
| 3 | Цалин | 116,530,150 | 7.69% |
| 4 | Түрээс | 4,954,955 | 0.33% |
| 5 | Зар сурталчилгаа | 13,082,758 | 0.86% |
| 6 | Мэргэжлийн үйлчилгээ | 19,047,550 | 1.26% |
| 7 | Найдваргүй авлага зардал | 50,463,572 | 3.33% |
| 8 | Бусад зардлуудын дүн | 91,588,575 | 6.04% |
| | **Дүн** | **1,516,070,768** | **100%** |



# Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

Энэхүү мэдээллийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-аас 2021 оны 4-р сарын 8-ний өдрийн байдлаар авсан тархалтын судалгаанаас харахад хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.



GENCO TOUR
BUREAU JSC

# ХИЙГДСЭН АЖЛУУД

## Бид хамтдаа хөтөлбөр

Ерөнхий боловсролын сурагчдад Монгол түүх, ёс заншилыг таниулах зорилгоор зохион байгуулдаг Бид хамтдаа хөтөлбөрийг УОК-н цуцлагдсан шийдвэрийн хүрээнд нийт 7 сургуулийн 426 хүүхдийг хамруулж Монголын түүх ёс заншлын мэдээллийг бодитоор хүргэсэн.









## Багц /13-р зуун/

Энэ жилээс 13-р зуун цогцолборт шинээр хэрэгжүүлж буй хөтөлбөр болох Тэмүүжин, Өүлэн, Өргөө, Гэрэгэ зэрэг багц хөтөлбөрүүд нь тус цогцолборын өнгөрсөн зуны голлох борлуулалтын нэг болж чадсан. Тус багцууд нь дотоодын жуулчдад Монгол ёс заншил, түүх соёл, малчны аж ахуйтай танилцах боломжийг олгосон нь үйлчлүүлэгчийн татах гол хөшүүрэг болсон. Ирэх онуудад гадаад жуулчдын урсгал нэмэгдвэл энэхүү багцуудыг сонирхох хандлагатай өндөр байгаа.



GENCO TOUR
BUREAU JSC

## Нүүдэлчин багц

13-р зуун цогцолборт түшиглэсэн бас нэгэн шинэ хөтөлбөр болох Монгол ёс заншил, малчны аж ахуйтай танилцах боломжийг олгосон НҮҮДЭЛЧИН багц хөтөлбөрийн энэ жилээс эхлэн зарласан ба тус хөтөлбөр намар болон өвлийн борлуулалт буусан үе буюу 13-р зууны хааны отог буусны дараах өвөлжөөг түшиглэсэн хөтөлбөр юм.









# Галын тахилга

2021.05.21-ний өдөр галын тахилга 2021 эвент арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан ба тус арга хэмжээгээр гадаад 42, дотоодын нийт 32 нийт 75 хүн хамрагдсан. Уг арга хэмжээний үеэр галын тахилгын зан үйл болон малчин айлын хоттой танилцах, нум сумаар харвах, морь унах зэрэг олон сонирхолтой үйл ажиллагаа явуулсан.






GENCO TOUR BUREAU JSC

# Малчны хоттой танилцах аялал









GENCO TOUR BUREAU JSC

## Хүүхдийн баярын арга хэмжээ

Жил болгон зохион байгуулагддаг “Чингисийн үрсийн баяр” хүүхдийн баярын арга хэмжээ энэ жил цомхон хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд хүүхдийн гар зургийн уралдаан хэлбэрээр зохион байгуулагдаж шалгаруулалтын дүнгээ гаргасан. Мөн эцэг эхтэйгээ ирсэн эхний 100 хүүхдэд гарын бэлэг бэлэглэж бяцхан багачуудыгаа баярлуулахын хажуугаар борлуулалтыг дэмжих үйл ажиллагаа явуулсан.









GENCO TOUR
BUREAU JSC

## Монгол бахархлын өдөр

2022.11.05-ний өдөр Монгол бахархлын өдрийг зохион байгуулав тус өдөрлөгөөр Морин хуур, уртын дуу, уран нугаралт, хөөмийн тоглолтыг зохион байгуулсан нь үйлчүүлэгч нарт ихээхэн таалагдсан.












GENCO TOUR BUREAU JSC

## Хуримын хүлээн авалт







10-р сард УОК-ын олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглох шийдвэр дуусмагц Чингис хааны морьт хөшөөт цогцолборт хуримын хүлээн авалтын захиалгыг авч эхэлсэн.

## Нууц нүүдэлчин эвент

2021.09.11-ний өдөр 13-р зуун цогцолбор дээр SECRET NOMADS арга хэмжээг амжилттай зохион байгуулагдсан. Уг арга хэмжээг тодорхой хүрээллийн дунд, тодорхой шаардлагын хүрээнд нууц хэлбэрээр зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр урлагын тоглолт, тусгай үзүүлбэр, салют буудуулах зэрэг хөтөлбөрүүд явуулсан.






## Шинэ жилийн хүлээн авалт





Чингис хааны морьт хөшөөт цогцолборын Алтан ташуур ресторанд байгууллагын шинэ жилийн хүлээн авалтыг авч зохион байгуулсан.

GENCO TOUR
BUREAU JSC

## Малдивын аялал

Cruise tour компанитай хамтарч Малдивын шууд нислэгтэй 6 шөнө 7 өдрийн аяллын бүтээгдэхүүний мэдээллийг сошиал сувгаар хүргэх замаар борлуулалтын үйл ажиллагаа амжилттай явуулсан.






GENCO TOUR
BUREAU JSC

## Ногоон картны сугалаа

2022 оны 10 сараас 11 сарын хооронд АНУ-ын ЗГ-аас хэрэгжүүлдэг гадаад иргэдэд иргэншил олгох ногоон картны сугалаанд дотоодын иргэдийг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Уг үйлчилгээг цаашид жил бүр хийх боломжтой ба илүү өргөн цар хүрээг хамруулах боломжтой.






GENCO TOUR
BUREAU JSC

## Сошиал маркетинг










Сошиал сувгаар дамжуулж компанийн үйл ажиллагаа болон арга хэмжээнүүдийн мэдээллийг иргэдэд тогтмол хүргэсэн.

## Сошиал маркетинг




Засгийн газраас тогтоосон хөл хорионы үед Чингис хааны морьт хөшөөт цогцолбор, 13-р зуун цогцолборуудын үйл ажиллагаа хязгаарлагдсан хэдий ч борлуулалтын бусад сувгуудыг идэвхижүүлж сувинерийн борлуулалтыг нэмэгдүүлсэн.

## Видео контент












Сошиал сувгаар дамжуулж компанийн үйл ажиллагаа болон арга хэмжээнүүдийн мэдээллийг иргэдэд тогтмол хүргэсэн.

GENCO TOUR
BUREAU JSC

# БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

## ГАДНА КАФЕ

Чингис хааны морьт хөшөөт цогцолборын гадна талд борлуулалтыг дэмжих зорилгоор ус ундаа хөнгөн зууш кофе худалдаалах үйлчилгээ бүхий кафе бий болгосон. Тус кафе нь Монгол ёс заншлыг гадаад жуулчид болон хүүхэд залуучуудад таниулах ач холбогдолтой юм.

SHEEP CAFÉ





ГЭР БААЗ ОРЧМЫН САРАВЧ

Чингис хааны морьт хөшөөт цогцолборын гадна байрлах гэр бааз орчимд амрагчдад зориулсан саравч байршуулсан.





GENCO TOUR BUREAU JSC

| ӨМНӨ | ДАРАА |
| --- | --- |









## Байнгын үзэсгэлэнгийн танхим



Байнгын үзэсгэлэнгийн танхим нь Монголын эзэнт гүрэн сэдвээр дэглэгдэхээр төлөвлөгдсөн.
Одоогоор Бурханы шашны шүтээн урлаг сэвдээр үзэсгэлэн дэглэгдсэн байгааг үндсэн сэдвийн дагуух үзмэр хуулбарлалт, худалдан авалт хийгдэж дууссаны дараа шинэчлэн дэглэгдэх болно.



# ГОЛ БАГАНА

Тус багананд
- Гүюг хааны тамганы дардас
- Чингисийн чулууны бичиг
- Хархорумын бичээс

Хананд
Монголын түүх, соёлын
газрын зургийг байрлуулсан





**Хархорумын 1346 оны бичээсийн утга**

Тайзү Шэнвү хаан /Чингис хаан/ ширээнд заларсан **15 дахь он** буюу 1220 онд тэр **Хэлин /Хархорум/-ийг Нийслэл /орд өргөө/-ээ болгохоор тогтов.** Тайзүн /Өгэдэй хаан/ хааны ивээлд **бүх хүн амьтан энх тунх, өнөр өтгөн байлаа. Хаан бээр** /тэнд/ **анх удаа нэгэн ордныг барьж байгуулав. Тиймээс нэгэн буддын шашны сүм ч барилаа.**

Гол асар нь таван давхар. Өндөр нь **300 тохой. Хамгийн доод давхар** дөрвөн талдаа танхимтай.



**ГҮЮГ ХААНЫ ТАМГАНЫ ДАРДАС**

Захидал дээр Монгол бичгээр " Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг ил буха иргэн доор хүрвээс биширтүгэ, аюутугай" гэсэн 6 мөр 15 үгтэй тамганы дардас буй. Эрдэмтэд уг тамга нь Гүюг хааны захидал дээр дарагдсан боловч угтаа Чингис хааны үеэс уламжлан их хааны гар дамжин ирсэн Их Монгол Улсын төрийн тамга гэж үздэг байна.



**ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ**

Монголчууд Хорезм улсыг байлдан дагуулсан аян дайнаас буцах замдаа Эрчис мөрний эрэгт зусаж Их Монгол улсын ноёдын хуралдай хуралдуулан өргөн дэлгэр хурим найр хийсэн аж. Хуралдайн үеэр Есүнгэ /1190-1270/ мэргэн 335 алд газарт бай харван оножээ. Түүний энэхүү хосгүй мэргэн харвасан алдрыг нь дуурсган хөшөө дурсгал босгосон нь хожмоо "Чингисийн чулууны бичиг" хэмээн алдаршсан билээ. Ингэж нэрлэх болсон учир гэвэл бичээсийн тэргүүнд Чингис хааны нэрийг мөр тэтгэн бичсэн байдагтай холбоотой.

Чингис хааны нэрийг дээд мөрнөөс, Есүнгэ мэргэний нэрийг арай доороос, бусад үгийг түүний доод түвшингээс эхлэн бичсэн байдаг нь 13-р зууны эхэн үед монгол албан бичгийн гол ёс болох мөр тэтгэн бичих зарчим хэдийн хэвшин тогтсон байсныг гэрчилнэ. Бичээст Есүнгэ мэргэний гайхалтай хол харваж, мэргэн оносон тухай тухай өгүүлэх тул судалгааны бүтээлүүдэд "Есүнгэгийн чулууны бичиг" гэх болжээ.

Гэрэлт хөшөөг 1224 он юмуу, эсхүл 1225 оны үед босгосон гэж судлаачид үздэг.

# Түр үзэсгэлэнгийн танхим



Түр үзэсгэлэнгийн танхим нь 6 сар тутамд үзмэрээ сэлгэн шинэчлэгдэн дэглэгдэж байхаар төлөвлөгдсөн.
2022 оны 5 сарын 1 ны Монголчуудын цайны соёл үзэсгэлэнг Морин хуурин соёл үзэсгэлэнгээр шинэчлэн дэглэхээр төлөвлөж байна.



GENCO TOUR
BUREAU JSC

# ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

GENCO TOUR BUREAU JSC

ЗАСВАР ТЭГШИЛГЭЭНИЙ  АЖЛУУД








GENCO TOUR
BUREAU JSC

ГЭР БААЗЫН ЗАСВАР /Гэрийн бүрээс/








Цахилгааны засвар
ГҮЙЦЭТГЭГЧ: НАРНЫ ЦАГ ХХК









ДЭЭВРИЙН ЗАСВАР
ГҮЙЦЭТГЭГЧ: ОНДИЛТ ХХК







GENCO TOUR BUREAU JSC

**Анхаарал хандуулсанд баярлалаа**

